

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны ... дугаар ...

сарын-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.9 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 254 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам”-д дараах агуулга бүхий хэсэг нэмсүгэй:

“3.5. Энэ журмын 3.3.1-д заасны дагуу Засгийн газрын дотоод үнэт цаасны нээлттэй арилжаанд оролцох хуулийн этгээд нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

3.5.1.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд байх;

3.5.2.Үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд сүүлийн 3 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан байх;

3.5.3.Засгийн газрын үнэт цаасны арилжаанд оролцож байсан туршлагатай байх;

3.5.4.Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй байх;

3.5.5.Татварын байгууллагад татварын өргүй байх;

3.5.6.Хамгийн бага шимтгэл, хураамж санал болгосон байх;

3.5.7.Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн дөрвөн улирал ханган ажилласан байх;

3.6.Энэ журмын 3.5-д заасан шалгуурыг хангасан үнэт цаасны арилжаанд оролцох эрхтэй хуулийн этгээд нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын нэрийн өмнөөс Засгийн газрын нээлттэй арилжаанд оролцох хүсэлтээ дараах баримт бичгийн хамт Нийгмийн даатгалын ерөнхий газарт тогтоосон хугацаанд ирүүлнэ. Үүнд:

3.6.1.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар;

3.6.2.өмнөх оны жилийн эцсийн аудитлагдсан тайлан;

3.6.3.Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн дөрвөн улирал ханган ажилласан эсэх тухай тодорхойлолт;

3.6.4.Засгийн газрын үнэт цаасны арилжаанд оролцсоныг гэрчлэх арилжааны хуулга;

3.6.5.санал болгож буй шимтгэл, хураамжийн мэдээлэл.

3.7.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь энэ журмын 3.6-д заасан баримт бичиг болон Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх Мэргэжлийн хорооны санал, дүгнэлтийг үндэслэн үнэт цаасны нээлттэй арилжаанд оролцох нэг хуулийн этгээдийг жил бүр сонгоно.

3.8.Энэ журмын 3.7-д заасан сонгон шалгаруулалтад оролцох Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан тушаалтан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу үнэт цаасны арилжаанд оролцох эрхтэй сонгогдсон хуулийн этгээдтэй ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

3.9.Нийгмийн даатгалын ерөнхий газар энэ журмын 3.8-д заасны дагуу үнэт цаасны арилжаанд оролцох эрхтэй сонгогдсон хуулийн этгээдтэй үнэт цаасны арилжааны шимтгэл, нууцлалын талаар нарийвчилсан нөхцөлүүдийг тусгасан гэрээг байгуулна.

3.10.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх Мэргэжлийн хорооны санал, дүгнэлт, Монголбанкны бодлогын хүү, Засгийн газрын нээлттэй үнэт цаасны зах зээлийн хүү, Засгийн газрын нээлттэй арилжаалахаар зарласан үнэт цаасны хэмжээ, хугацааг харгалзан Засгийн газрын үнэт цаасны нээлттэй арилжаанд оролцох үнэт цаасны хүү болон мөнгөн дүнгийн саналыг энэ журмын 3.9-д заасан хуулийн этгээдэд хүргүүлнэ.

2.Журмын 3.4 дэх хэсгийн "3.3.1-д" гэснийг "3.3.2-т" гэж өөрчилсүгэй.

3.Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ